

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Адъяа	Дугаар	L267
Оршин суугаа аймаг	Төв аймаг	Оршин суугаа сум	
Төрсөн газар	Жаргалант сум	Төрсөн он	1927
Ажил мэргэжил	Өндөрнастан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Зөөхэйн хурал	Сүм хийдийн дугаар	ТӨЖР 033
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны10-рсарын 24	Ярилцлага авсан хүн	Д .Мөнхбат

Төв аймгийн Жаргалант сумын Зөөхэйн хурал

Мөнхбат: Жаргалант сумын төвөөс баруун хойшоо 40-өөд км-ын зайд байх Зөөхий хэмээх газрын хойд эх, Нугат шанага хэмээх газрын уулзвар дээр байх Зөөхэйн хурал гэж цагтаа энэ бүс нутгийн буддын шашны төв газар байсан энэ хүрээ хийдийн тухай судалгааны ажлаа үргэлжлүүлж байна. Энэ судалгааны ажилд энэ Зөөхэйн хүрээний тухай мэдээлэл өгөхөөр Жаргалант сумын Загдал багийн төв дээр суудаг өндөр настан эдүгээ 80 насыг зооглоод байгаа Адъяа гуайтай бид нар дараах ярилцагыг хийсэн юм аа. Тэгэхээр Адъяа гуйагаас би нэг хэдэн зүйлийг онцолж асууя. Та өдгөө наяд гаруй насыг зооглоод байж байна. Багадаа энэ Зөөхэйн хүрээнд сууж бурхны номны эхний үсгийг заалгаж, цан хэнгэрэг цохиж явсан гэж таныг сонссон. Тэгэхээр та энэ тухайгаа ингээд дурсахгүй юу?

Адъяа: За тэр үед чинь одоо нэг ном уншиж байхад чинь бол одоогоор бол бага сургуулийн л хүүхэд гэсэн үг юм даа. Янз бүрийн үсэг заалгасан шиг, мөн тал захтай дээл өмссөн шиг мөн ламын юунд орсон шин ингэж л явлаа даа. Мэдэх юмаар ч маруухан шиг. Сайхан хүрээ хийд байлаа даа, манай дуган бол. Олон юутай...

Мөнхбат: Тэгэхээр Зөөхэйн хүрээ маань таныг сууж байхад хичнээн ламтай байсан юм бол, мөн хэдэн дугантай байсан юм бол, лав нэг гэр дуган байсан шиг байна. Гадуураа хэрмэн хашаа байсан шиг байна. 2,3 том жижиг дугануудын үл мөр харагдаж байна?

Адъяа: 2, 3 том дугантай, цогчин дуган юу дуган гээд. Ер нь нэг 50, 60 лам байсан байгаа юм шүү. Гаднаас ирдэг нь хааяа нэг их хурал хурдаг бололтой юм, тэр чинь. Сор гэдгийг чинь хэрийн бага газар залахгүй шүү. Тэгэхээр энэ нилээн сор зална гэдэг чинь одоогоор кинонд нэг гардаг шүү дээ. Тэрийг мэднэ биз дээ. Ганжуур гэдэг чинь одоо зуны цагийн нэг үйл юм даа. Майдар эргэнэ, дандаа зуны цагт л хийдэг. Ногоон морин дээр гоёчихсон, тийм л юм тэр ард түмнийхээ дундуур л бас л үзүүлж сонирхуулж байсан юм уу даа. Лам хувраг нь ном момоо яачихсан...

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Мөнхбат: Тэгэхээр энэ Зөөхэйн хүрээнд дээр сор залдаг байж, майдар эргэдэг байж, ганжуур гээд.Цам харайх юм байх уу?

Адъяа: Тэрийг нь би мэдэхгүй юм байна.

Мөнхбат: Ийм шашны зан үйл явуулдаг байж. Та түрүүн гаднаас лам нар ирж хурдаг гэлээ. Ер нь бол байнгын ажиллагаатай хүрээ байсан юм уу?

Адъяа: Энд тэндээс хааяа нэг том том хурал хийхээр бас нэг оролцдог юм шиг байгаа юм. Заримдаа лам их олон болчихсон байдаг.Заримдаа бол хэвийн байдаг байхгүй юу. Тэгэхээр би өөрөө одоо бодож байгаа байхгүй юу. Энэ тэр том том ямар чухал хурал хийхээр тэр хийд тэр юу, энэ Хубилай хааны жаргалантын дэнжээс нэг нэг төлөөлөл лам ирж ном хурал хийдэг юм байна гэдгийг л бодож байхгүй юу.

Мөнхбат: Тэгэхээр энэ гадна талын хэрмийн түүрийг харахад нэлээн том хэрэм байсан болов уу гэж харагдаж байна. Энэ хэрэм хэр өндөр байсан юм бол, ямархуу материалаар хийсэн байсан юм бол?

Адъяа: Тэр чинь байна ш дээ, гадна тал нь шавар байсан юм. Одоо ингээд үзэхэд дотор тал нь нэг их том өргөн хөх түүний байгаа, гадна талаараа хар шавар шавчихаад.Тэр Аравт гээд нэг бригад байна, тэндээс харагддаг.Тэр чинь урд төрх нь талаасаа бол их том хэрэм шүү.

Мөнхбат: Цээлийн тэр Аравт бригад тийм ээ?

Адъяа: Зөөхэйн Аравт бригад. Тэр дуганы суурингаас урд нэг гол гарад Лүн гэж овоотой толгой байдаг юм.Тэрнээс харагддаг хэрэм байхгүй юу. Тийм том сүртэй, тэгээд энэ ерэн хэдэн оноос алга болчихсон ш дээ.

Мөнхбат: Тэгэхээр энэ хүрээний урд талаар ч байна, хойд хөдөө талаараа ч байна суварга ч юм уу, хүрднийх ч юм уу овоолсон шороон сууриуд их байна аа. Ардаа бол 5 их тод харагдаж байна.Тэгэхээр энэ одоо юу байсан юм бол, хичнээн суварга хүрд байсан юм бол?

Адъяа: 21 байсан болов уу.

Мөнхбат: Тэр яг суварганы суурь мөн үү?

Адъяа: Мөн, тэр чинь одоо ингээд тээрмийн юу ч хоёр талд нь суулгасан байгаа шүү. Уг нь далан хэдэн оны үед бол суварга нь суварга гэхээр байсан юм, арай суурь болоогүй. Тэгтэл өнөө тээрэм мээрэм юу хэрэгтэй болохоор тэр дор бас хэрэгтэй юм байсан байна. Суварган доор бас юм хийж байсан байна шүү. Тэрийг нь ухаж юу ч олж авч байсан юм, мэдэхгүй ээ .Тэгээд л бүр байхгүй ээ.Тэр чинь одоо энэ шатаж барьж, тийм л түүнийгаар яаж, гадна талыг нь харин харшавраар шавчихсан байж.Тэгээд сүүлийн үед харин байшин барилга барих хэрэгсэл рүү тэрийг зөөгөөд барилга барьчихгүй юу.

Мөнхбат: Жас хөрөнгийн хувьд Зөөхэйн хүрээ мань хэр том жастай байсан юм бэ?

Адъяа: За мэдэхгүй ээ, үхэр мал байсан л юм, жасын гээд. Яг хичнээн байсныг нь мэдэхгүй ээ.

Мөнхбат: Та одоо лам нарын тоог мэдэж байна уу, багцаагаар тэд орчим лам гээд байнгын яг хэвийн үедээ?

Адъяа: Хэвийн үедээ нэг хоёр дуган дүүрэн дөч шахуу лам байсан байх аа. Яахав гурван дуган дүүрэн хүүхэд, доохнуур л тэр томчууд чинь...

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Мөнхбат: Таныг сууж байхад тэр хүрээ хаагдахаас өмнө хүрээний хамба лам нь ч гэдэг юм уу, тэргүүн гэдэг юм уу тэр лам нь ямар хүн байсан юм бол?

Адъяа: Шандаг лам гэж байсан юм.

Мөнхбат: Ямар цол хэргэмтэй хүн байсан юм?

Адъяа: Мэдэхгүй ээ, тэрийг чинь нэг л шөнө аваад юу яагаад бариад явчихсан юм гэдэг. Тэр Шандаг ламыг чинь одоо бариад, зарим нь болохлээр тэр Оросын нутагт одоо их сайн байна гэнэ ээ. Гадаад явсан хүн, одоо наяд гараад нутагтаа ирнэ гэнэ ээ гэсэн юу л байсан. Ирсэн ч юм байхгүй, үнэн ч юм уу, худлаа ч юм уу мэдэхгүй ээ. Хүүхэд нь Лувсандагва гээд том ламын хүү чинь туслах үнзад байсан юм. Тэрний хүүхэд Лхагвадорж гээд байсан нас барчихсан юм. Өөр юм байхгүй ээ.

Мөнхбат: Тэгэхээр тэр 1937, 1938 оны хэлмэгдүүлэлтийн жилүүдэд, тэр лам нарыг том жижиггүй барьж авч хэлс хэрэгт шийтгэж байсан тэр он жилүүдэд энэ Зөөхэйн хүрээнээс хичнээн лам баригдаж явсан юм бол, хэд нь буцаж ирсэн юм бол, эргэж ирээгүй нь хэр байдаг юм бол? Та энэ талаар санаж байгаа юм байна уу?

Адъяа: Үгүй ээ ер нь том ламаас нь өөр баригдаагүй байх аа. Яагаад вэ гэхлээр үнзад нь үлдсэн юм байгаа юм. Гэсгүй нь урьд нь юу сонсож байсан юм болов уу, яагаад баригдаагүй юм бол оо. Гэсгүй нь үлдсэн байгаа юм. Тэгэхээр тэрнээс доош лам нарыг бариагүй байх аа, тийм ээ.

Мөнхбат: Тэгээд л хар болгоод л?

Адъяа: Тэр үнзад чинь лам байсан хүн чинь, ном үзэж байсан хүн чинь үгүй арай урд дуулиан байсан байх. Авгай аваад хүүхэд шуухадтай болоод, амь тэжээнэ гэдэг чинь хатуу цаг байж. Тарвага алаад хүртэл цохиж явлаа шүү дээ.

Мөнхбат: Тэгэхээр таны санахад 1937 онд хүрээ хийдийг хаагаад лам нарыг нь хар болгочихоод хүрээ хийд эзгүйрээд он удаан жил болсон уу, эсвэл дараа нь тэр дор нь лам нарыг нь барьчихаад буулгаж шатаагаад устгасан уу, байгаад байсан хүрээ хийд энэ талаар та юу санаж байна?

Адъяа: Гуулин бурхнуудыг чинь зүгээр хөл гарыг нь салгаад энэ гууд шалзалж харагдаж байсан юм шүү. Нэг л хүний хөл, нэг л хүний толгой... Тэгэхлээрээ тэр эвдэж сүйтгэж байсан байх аа.

Мөнхбат: Дуганууд нь ерөөсөө дөч тавиад оны нүүрийг үзсэн үү?

Адъяа: Үзээгүй, тэр дөчин хэдэн онд хэн хаашаа авч явсан юм бүү мэд.

Мөнхбат: Нураагаад л байхгүй болсон?

Адъяа: Байхгүй, би чинь одоо тийшээ ч зүглэх ч үгүй болсон шүү дээ. Тэр дуган сүмийг хаашаа авч явсан юм, бүү мэд. Тэр үед чухам сэргэлэн нэг нь буулгаад авч явсан юм уу, засаг төр нь аваад явч байсан юм уу, бүү мэд. Арай ч тэр бурхны юманд халдаж байгаагүй л дээ.

Адъяа: Тэгэхээр энэ Зөөхэйн хүрээ Түшээт хан аймгийн Баатар вангийн хошууны одоо энэ хойд бие одоогийн энэ Жаргалант угтаалын нутагтаа бол бурхан шашны нэлээн том төв байсан юм шиг байна, тийм ээ. Жишээлбэл, одоо энэ Жаргалант сумаар жишээ авахад Жаргалант сумын Дэлгэр булангийн хурал байдаг юм уу, Ногоон нуурын хурал байдаг юм уу за мөн Жаргалант угтаалын нутагт байж байгаа Хүүлээ хааны ар өвөрт байж байгаа

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ар булагийн хурал номын газар байна тийм ээ. Эд нартай харьцуулах юм бол буурь туурийг нь харахад том хүрээ байжээ. Тэгэхээр эндээс төрж гарсан одоо шашин номын гэгээрэлд хүрсэн эрдэмтэй лам нар олон байсан байх, тийм ээ. Тэгэхээр таны санаж байгаагаар ямар ямар эрдэмтэй чадалтай лам нар байсан юм бол оо? Энд санаж байгаа юм юу байна?

Адъяа: Санахгүй. Одоо бодоход л тэр хамба л их том хүн байсан болов уу. Эрдэм номтой. За унзад бас аюулгүй л байсан байх аа. Унзад гэдэг чинь бас л ...

Мөнхбат: Сүүлчийн унзадыг та хэдий хэр наслаад бурхан болж гэж түрүүн дурдаж байсан бэ?

Адъяа: Одоо энэ далаад оны үед чинь ямар ч гэсэн 70 гарсан л хүн байсан. Махгаандорж гэж нэртэй ,их бүдүүн дуутай тийм үр хүүхэд нь байдаг л юм одоо.

Мөнхбат: За та ямар ч гэсэн бурхан шашин хаагдахын өмнө ямар ч гэсэн энэ хүрээнд нэг зурвасхан хоёр жил суугаад авжээ. Таны багш ямар хүн байсан бэ, нэрийг хэлж болмооргүй бол хэлэхгүй байж болно?

Адъяа: Үгүй, яахав болно оо. Миний багш чинь тэр Дугаржав гэж л хүн байсан юм.

Мөнхбат: Ямар зиндаатай хүн байсан юм бол?

Адъяа: Мэдэхгүй ээ, тэр зоч л хүн байсан. Ямар хэргэм зэрэгтэй юм, ер нь тэрүүхэн үедээ л байна ш дээ. Тэр хүн тавьдаг, жодгортой л явдаг. Өөр авгай, хүүхэд нь гээд л хэсч явдаг л тийм хүн байсан.

Мөнхбат: Та хурал номын үеэр доохнуур сууж байсан, цан хэнгэрэг цохиод гэж байна. Тэгэхээр таны үүрэг ямар үүрэгтэй байсан?

Адъяа: Үгүй ээ, яахав бас цав манзхан бас юу яана шүү дээ. Цав манз зөөдөг, багш нартаа аягалдаг ийм л үүрэгтэй хүн. Тэгээд хоол унд юу яахад чинь тэр...Манай багш тийм л хүн байсан. Дээр үед чинь тэр ламын дэг жаяг гэдэг чинь тэр үедээ л, одоо ямар байдаг юм , одоо үгүй дээ нэг манз аягалаад өгөхөд чинь зүгээр аваад идэхгүй ээ лама гомбу ир мадлаа даг, дэвий дэсигчи давий самжаан даг, саижид чи гээд бас нэг манзны уншлага уншдаг ухааны.

Өсөхбаяр: Танай багш чинь тэгээд хурлын лам байсан юм уу, дугандаа бол хаанаа суудаг байсан юм?

Адъяа: Өө нэлээн дээрээсээ 2, 3-т л суудаг лам байсан.

Өсөхбаяр: Хамба биш, унзад биш?

Адъяа: Биш, тэрнээс доошоо л .Тэр чинь эхлээд хамба сууна. Тэрнээс доор унзад сууна. Тэрнээс доор туслах унзад суудаг байв уу иймэрхүү л байсан юм даа.

Өсөхбаяр: Тэрний доохнуур сууж байсан юм уу?

Адъяа: Тэрний доохнуур.

Өсөхбаяр: Хэд орчим настай хүн байсан юм?

Адъяа: Ээ дээ настай хүн байсан даа.

Өсөхбаяр: Лүйжингээ бол тусад нь тавьдаг?

Адъяа: Тусад нь өөрөө зуны цагт л тавьдаг байхгүй юу, өвлийн цагт эндээ суудаг. Зуны цагт хөдөөгүүр явдаг.

Өсөхбаяр: Тийм зоч тавьдаг лам нар олон байсан уу?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Адъяа: Өө цөөхөөн.Тэр том зоч багш л гэдэг.

Өсөхбаяр: Танай багшийнх чинь хийдийнхээ хаагуур байсан юм?

Адъяа: Тэр хийдийн баруун талаар байсан.

Өсөхбаяр:Танай хийдийн ойр орчимд бааюу байсан уу?

Адъяа: Байхгүй.

Өсөхбаяр: Бааюуны ийм тоосгоо хаанаас олж байсан юм, бааюу шатааж байгаагүй юу?

Адъяа: Шатааж байсан юм болов уу, хэдийд шатааж байсан юм , би мэдэхгүй юм аа.

Өсөхбаяр: Бааюу гэж хуучны тоосго шатаадаг ийм юу байдаг ш дээ?

Адъяа: Байхгүй, энэ бол Хятадын төмөр шиг хөх түүпий.

Өсөхбаяр: Энэ хийдийн ойр орчимд Хятадууд байсан байлгүй дээ?

Адъяа: Өө энэ Шанаганы адгаар Хятад их байсан юм.

Адъяа: Шанаганы наад талын өвдгөөр чинь шавар юуны одоо ийм хонхор шиг, тэр үед чинь хятадууд газар ухаад л газар доогуур нь барай их байсан ш дээ. Тэд нар цохиж байсан юм болов уу.

Мөнхбат: За таньд баярлалаа. Ингээд энэ өөрийн нутаг орон дахь томоохон хаурал хийдийн газар болох Зөөхэйн хийдийн тухай мэдэж, сонсож, үзэж харснаа бидэнтэй хуваалцсанд баярлалаа. Танын өгсөн энэ мэдээлэл манай судалгааны багийн ажилд үнэтэй хувь нэмэр оруулна гэдэгт итгэж байна аа.

Адъяа: Би бас бодож байгаа юм. Энэн дээр нэг юм энэ хийд дээр тал захтай дээл өмсч байхад, бага насаа өнгөрөөж байхад энэн дээр их ч бол, бага ч бол дурсгалын самбар ч юм уу, нэг суварга ч юм уу босгоё гэж. Бодсон чинь лав л энэ жилдээ бүтсэнгүй ээ. Хоёр ч жил болж байна даа, би ИТХ-д санал тавиад.Тэгэхдээ тэр мүү хүүхэд их хөөцөлдсөн.